



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

30.00 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 44/164

Арвайхээр

### Захирамжийн хавсралтад нэмэлт өөрчлөлт тухай

Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны "Орон тооны жишиг норматив батлах тухай" А/024/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Орон тоо батлах тухай" аймгийн Засаг даргын 2020 оны А/54 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулиудын 2020 оны багш, ажиллагсдын орон тоо"-ны 2 дахь хэсгийн Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн багш 109 гэснийг 110 гэж, 4 дэх хэсгийн Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн багш 81 гэснийг 82 гэж, 5 дахь хэсгийн Арвайхээр сумын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн багш 12 гэснийг 13 гэж, 29 дэх хэсгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Баянтээг сургуулийн багш 6 гэснийг 7 гэж, гуравдугаар хавсралтаар баталсан "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2020 оны багш, ажиллагсдын орон тоо"-ны 32 дахь хэсгийн Нарийнтээл сумын цэцэрлэгийн хүмүүжлийн багш 4 гэснийг 5 гэж, туслах багш 4 гэснийг 5 гэж, 39 дэх хэсгийн Хайрхандулаан сумын цэцэрлэгийн дуу хөгжмийн багш 0 гэснийг 1 гэж тус тус өөрчлөн нэмсүгэй.

2.Батлагдсан орон тоог 2020 оны төсвийн жилд мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагчид үүрэг болгосугай.

3.Батлагдсан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаярт)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ

О. БАТЖАРГАЛ



011101029